



# МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2015 оны 12 дугаар  
сарын 8-ны өдөр


Дугаар 247

Улаанбаатар  
хот

Үндэсний хорооны бүрэлдэхүүн, ажиллах  
журмыг шинэчлэн батлах тухай

1. Агаарын бохирдлыг бууруулах бодлогын хэрэгжилтийг зохицуулах, үйл ажиллагааны харилцан уялдааг хангахад хяналт тавих үүрэг бүхий Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 1 дүгээр, тус Үндэсний хорооны ажиллах журмыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан “Үндэсний хорооны бүрэлдэхүүн, ажиллах журам шинэчлэн батлах тухай” Ерөнхий сайдын 2014 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 151 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Байгаль орчин, ногоон хөгжил,  
аялал жуулчлалын сайд

Ч.САЙХАНБИЛЭГ

Н.БАТЦЭРЭГ

Ерөнхий сайдын 2015 оны 247 дугаар  
захирамжийн 1 дүгээр хавсралт

АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ  
ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга -Монгол Улсын Ерөнхий сайд
- Дэд дарга -Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд
- Гишүүд:
- Улсын Их Хурлын Агаарын бохирдлыг бууруулах асуудлын Дэд хорооны дарга (зөвшилцсөнөөр);
  - Нийслэлийн Засаг дарга;
  - Баянхонгор аймгийн Засаг дарга;
  - Дархан-Уул аймгийн Засаг дарга;
  - Орхон аймгийн Засаг дарга;
  - Өвөрхангай аймгийн Засаг дарга;
  - Өмнөговь аймгийн Засаг дарга;
  - Хөвсгөл аймгийн Засаг дарга;
  - Ховд аймгийн Засаг дарга;
  - Монгол Улсын Ерөнхийлөгчийн амьдрах орчин, ногоон хөгжлийн бодлогын зөвлөх (зөвшилцсөнөөр);
  - Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
  - Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга;
  - Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
  - Уул уурхайн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
  - Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга;
  - Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын дарга.
- Нарийн бичгийн дарга:
- Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны дарга;
  - Нийслэлийн Засаг даргын экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч.

## АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ АЖИЛЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Агаарын тухай хуулийн 6.1.1<sup>1</sup>-д заасан агаарын бохирдлыг бууруулах бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, үйл ажиллагааны харилцан уялдааг хангахад хяналт тавих үүрэг бүхий Үндэсний хороо (цаашид “Үндэсний хороо” гэх)-ны үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Үндэсний хороо нь үйл ажиллагаандаа агаарын бохирдлыг бууруулахтай холбоотой Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, энэхүү журмыг удирдлага болгоно.

### Хоёр. Үндэсний хорооны үйл ажиллагааны зохион байгуулалт

2.1. Үндэсний хорооны үйл ажиллагаа явуулах үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Үндэсний хорооны хуралдаанд дарга, гишүүд таслах эрхтэйгээр оролцоно. Хуралдааныг гишүүдийн олонх нь оролцсоноор хүчинтэйд тооцно.

2.2. Үндэсний хорооны ээлжит хуралдааныг улирал тутамд зохион байгуулна. Шаардлагатай тохиолдолд Үндэсний хорооны даргын санаачилгаар ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулж болно.

2.3. Хуралдааныг Үндэсний хорооны дарга даргална. Үндэсний хорооны даргын түр эзгүйд хуралдааныг дэд дарга даргална.

2.4. Үндэсний хорооны гишүүн-аймгийн Засаг дарга тус хорооны ээлжит хуралдаанаас 14 хоногийн өмнө холбогдох тайлан, мэдээг ирүүлнэ.

2.5. Үндэсний хорооны гишүүн ээлжит хуралдаанд биечлэн оролцох боломжгүй тохиолдолд хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан саналаа бичгээр ирүүлж болно. Энэ нөхцөлд тухайн гишүүнийг хуралд ирснээр тооцно.

2.6. Үндэсний хорооны нарийн бичгийн дарга нь хорооны өдөр тутмын үйл ажиллагааг хариуцаж, хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлын бэлтгэлийг хангана.

2.7. Үндэсний хороо нь үйл ажиллагаагаа улирал, хагас жил, жилийн хугацаагаар төлөвлөж, тайлангаа бүтэн жилээр хэлэлцэж дүгнэнэ.

### Гурав. Үндэсний хорооны чиг үүрэг

3.1. Үндэсний хороо нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. Агаарын тухай хуулийн 6.1-д заасан асуудлын талаар санал, шийдвэрийн төсөл боловсруулж Засгийн газрын хуралдаанд оруулах;

3.1.2. агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр холбогдох төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, төрийн бусад байгууллагуудын чиг үүрэг, ажлын заагийг тогтоож, хариуцсан ажлын хэрэгжилтэд нь хяналт тавих;

3.1.3. Агаарын бохирдлыг бууруулахад иргэдийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх, идэвх, санаачилгыг дэмжих, урамшуулах, агаарын төлөв байдлын тухай нийтэд мэдээлдэг ухаалаг тогтолцосг бий болгох талаар шаардлагатай арга хэмжээг авах;

3.1.4. агаарын бохирдлыг бууруулах талаар хийж байгаа ажлын биелэлтийн талаар холбогдох албан тушаалтны сонсгол, тайланг хэлэлцэх, шаардлагатай мэдээ, тайлан гаргуулан авах.

#### Дөрөв. Үндэсний хорооны шийдвэр

4.1. Үндэсний хороо нь хууль тогтоомж болон энэхүү журамд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэх бөгөөд шийдвэр нь тогтоол хэлбэртэй байна.

4.2. Үндэсний хорооны хуралдаанаас гарах шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн байна.

4.3. Үндэсний хорооны хуралдааны тэмдэглэлд хорооны дарга болон нарийн бичгийн дарга гарын үсэг зурна. Үндэсний хорооны даргын түр эзгүйд хуралдааны тэмдэглэлд дэд дарга гарын үсэг зурна.

4.4. Үндэсний хорооны гишүүд нь хуралдаанаас гарсан шийдвэрт хамтын хариуцлага хүлээнэ.

4.5. Хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан Үндэсний хорооны шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтан биелүүлэх үүрэгтэй бөгөөд явц, үр дүнг тогтоосон хугацаанд тогтмол тайлагнана.